



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/294

Хэрлэн сум

Арга хэмжээнд оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тогтоолын “Гадаад томилолтын зардлыг шинэчлэн батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Орд овогтой Сүхбаатар, Засаг даргын орлогч Дэвээ овогтой Отгонцэцэг, Байгаль орчны улсын байцаагч Энхбаатар овогтой Отгонтунгалаг нарыг 2018 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс 16-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын КёнГЖү хотод зохион байгуулагдах “2018 оны Дэлхийн орон нутгийн захиргааны соёлын аялал жуулчлалын наадамд” оролцуулсугай.

2. Гадаад томилолттой холбоотой бэлтгэл ажлыг зохион байгуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ж.Гантулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА